



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 нэрийн, нийт 4,792,000.00 (дөрвөн сая долоон зуун ерэн хоёр мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 2,396,000.00 (хоёр сая гурван зуун ерэн зургаан мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000945
15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 04-дөдрийн
546-дугаар тогтоолын хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮНЭ ШИНЭЧЛЭН ТОГТООХ, АШИГЛАЛТЫН ХУГАЦАА СУНГАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа		
						Цаашид ашиглах жил	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Ус цэвэршүүлэгч /HWY509/	2021-11-30	1	680,000.00	680,000.00	3	340,000.00	340,000.00
2	Тоос сорогч /Tornodo SMV/	2021-12-02	1	225,000.00	225,000.00	3	112,500.00	112,500.00
3	Микрофон /утасгүй/	2021-10-19	2	350,000.00	700,000.00	3	175,000.00	350,000.00
4	Дрож /хивс/	2021-11-24	1	2,387,000.00	2,387,000.00	3	1,193,500.00	1,193,500.00
5	Ариутгалын төхөөрөмж /үүрдэг/	2021-08-03	2	400,000.00	800,000.00	3	200,000.00	400,000.00
Нийт дүн			7 (долоо)		4,792,000.00 (дөрвөн сая долоон зуун ерэн хоёр мянга)			2,396,000.00 (хоёр сая гурван зуун ерэн зургаан мянган төгрөг)